

СУВИЛАГЧИЙН МЭРГЭЖЛЭЭР СУРАЛЦАГСДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Л.Отгонтөгс¹, Д.Оюунцэцэг²

¹АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Сургууль

Хүлээн авсан огноо: 2021.10.22

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор Д.Алтайхүү

Үндэслэл

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь ажиллах хүчийг хамгийн их шаарддаг салбар бөгөөд дэлхийн ихэнх орнуудад ажиллах хүчний 50-иас илүү хувийг сувилагч мэргэжилтэн бүрдүүлж байна. Тиймээс дэлхийн топ 10 мэргэжлийн жагсаалтын эхний тавд сувилагч мэргэжил багтдаг.[1.6] Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны амжилтын нэг чухал хүчин зүйл сувилахуйн мэргэжилтнүүд төдийгүй тэдний сэтгэл ханамжийн түвшин юм. Иймд сувилахуйн хүний нөөцийн хөгжилд хөрөнгө оруулалт хийх нь бусад нөөцөд хөрөнгө оруулалт хийснээс илүү үр ашигтай байдаг талаар ДЭМБ дурьдсан.[1]

Мэргэжлүүдийн талаар хэдий чинээ өргөн мэдлэгтэй байна төдий чинээ үндэслэлтэй сонголт хийж чаддагийг мэргэжил судлалын эрдэмтэд судалгаагаар нотолсон байдаг хэдий ч мэргэжлийн талаар мэдээлэл дутмаг, албан бус мэдээллийн эх үүсвэр ашигладаг зэрэг мэргэжлийн чиг баримжаа дутмаг байна (Монголын менежмент консалтинг. Мэргэжлээ сонгох нь. УБ.,2013). Иймээс суралцах сургуулиа тэр дундаа мэргэжлээ хэрхэн зөв сонгох, мэргэжил сонголтонд нөлөөлдөг хүчин зүйлсийг илрүүлэх нь боловсролын байгууллагын анхаарвал зохих асуудал төдийгүй аймаг, бүс нутгийн хэмжээнд олон жилийн давтамжтайгаар судлан тодорхойлох шаардлагатай байгаа учраас сувилагч мэргэжлээр суралцагчдын сэтгэл ханамжийг судлахыг зорилоо.

Зорилго

Сувилагчийн мэргэжлээр суралцагчдын сэтгэл ханамжийг тодорхойлж, сэтгэл ханамжид нөлөөлж буй зарим хүчин зүйлс болон сурлагын үзүүлэлтийн хамаарлыг судлан үнэлгээ өгөх

Зорилт

1. Сувилагчийн мэргэжлээр суралцагчдын сэтгэл ханамжийг тодорхойлж үнэлгээ өгөх
2. Сэтгэл ханамжид нөлөөлж буй зарим хүчин зүйлс болон сурлагын үзүүлэлтийн хамаарлыг тодорхойлох

Материал, арга зүй

Судалгаанд АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны сургуульд сувилагчийн мэргэжлээр суралцаж буй нийт оюутнуудаас 95 хувийн итгэх магадлалтайгаар алдааны хязгаарыг 5 байхаар тооцон энгийн санамсаргүй түүвэрлэлтийн аргаар 193 оюутныг асуулга судалгаанд хамруулав. Судалгааны

асуулгын хуудсыг сургууль сонгох болсон шалтгаан, сургалтын орчин, багшлах боловсон хүчин, сувилагч мэргэжлийг сонгоход нөлөөлсөн хүчин зүйлс, судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээлэл гэсэн 5 бүлэг, багшид өгөх сэтгэл ханамжийн үнэлгээ бүлгийг багшийн мэдлэг, чадвар, заах арга зүй, зан харилцаа гэсэн 4 дэд бүлэг, 28 асуулттай, сувилагч мэргэжил сонгоход нөлөөлсөн хүчин зүйлс бүлгийг мэргэжлийн нэр хүнд, гэр бүлийн нөлөө, ЭЕШ-ын оноо, мэргэжлийн эрэлт хэрэгцээ гэсэн 4 дэд бүлэг 17 асуулттай, ерөнхий мэдээллийн хэсэгт нас, хүйс, суралцаж буй дамжаа зэргийг оролцуулан боловсруулж Cronbach alfa-г тодорхойлж үзэхэд $\alpha > 0.81$ байсан тул асуулгын дотоод нийцтэй байдлыг найдвартай гэж үзэв. Оюутнуудын сэтгэл ханамжийг Ликертийн 1-5 оноогоор үнэлэв. 1 оноо-огт сэтгэл ханамжгүй, 2 оноо-сэтгэл ханамжгүй, 3 оноо-дунд зэрэг сэтгэл ханамжтай, 4 оноо-сэтгэл ханамжтай, 5 оноо-маш их сэтгэл ханамжтай гэсэн үзүүлэлтийг тодорхойлно. Судалгааны статистик боловсруулалтыг SPSS 25 програм ашиглан хийв.

Практик ач холбогдол, шинэлэг тал

Сувилагчийн мэргэжлээр суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны асуулгыг боловсруулж, дэд асуултуудын дотоод нийцтэй, найдвартай байдлыг статистик хэмжүүр ашиглан шалгаж, боловсруулсан нь шинэлэг юм.

Энэхүү судалгааны үр дүн сургалтын үйл ажиллагаа, олон нийтийн үйл ажиллагааг оюутны сэтгэл ханамжинд тулгуурлан явуулахад судалгааны үндэслэлтэй суурь болох юм.

Үр дүн

Судалгаанд хамрагдсан оюутнуудын 10% эрэгтэй, 90% эмэгтэй, насны дундаж үзүүлэлт 19.8 ± 1.63 байв. Тус сургуульд элсэн суралцах болсон шалтгаанд сувилагчийн мэргэжлээр суралцаж буй оюутнуудын 76.7% улсын сургууль, 87% багшлах боловсон хүчин сайн, 85% сургалтын чанар сайн, 84.4% төгсөгчдийн сэтгэл ханамж өндөр, 82.3% сургалтын төлбөр хэт өндөр биш, 62.7% мэргэжлийн сурталчилгаа сайн, 90.2% сургалтын орчин тав тухтай, 86.5% багш нарын харилцаа, хандлага сайн гэсэн үзүүлэлтүүдийг чухал, маш чухал гэж үнэлсэн байв.

Оюутнуудын мэргэжил сонголтонд нөлөөлсөн хүчин зүйлсийг тодорхойлж үзэхэд 30.2% нь ЭЕШ-ын онооноос шалтгаалж, 40.1% өөрийн хүсэлтээр, 25.4% гэр бүлийн нөлөөгөөр, 53.1% сувилагчийн мэргэжил эрэлт ихтэй (засгийн

газрын тэтгэлэгтэй), 41.5% мэргэжлийн нэр хүнд сайн гэсэн шалтгаанаар сувилагч мэргэжлийг сонгосон байв.

Оюутнуудын сэтгэл ханамжид багш нарын мэдлэг, чадвар, заах арга зүй, зан харилцаа хэрхэн нөлөөлж буйг Регрессийн шинжилгээгээр тодорхойлов. Регрессийн шинжилгээгээр оюутнуудын сэтгэл ханамжид нөлөөлж буй багшийн үйл ажиллагаатай холбоотой загвар дараах байдалтай гарсан.

R Square буюу детерминацийн коэффициент 0.933 гарсан байгаа нь багшийн мэдлэг, чадвар, заах арга зүй, зан харилцаа гэсэн 4 үзүүлэлт нь багшлах боловсон хүчинд өгч буй сэтгэл ханамжийн өөрчлөлтийн 93.3 хувийг тайлбарлаж байна. F-test 656.6 ($P=0.000$) байгаа нь бидний байгуулсан загвар статистикийн хувьд ач холбогдолтой, багшлах боловсон хүчний талаарх оюутнуудын сэтгэл ханамжийг тодорхойлж чадаж байгааг харуулж байгаа юм.

Шинжилгээний үр дүнгээс харахад Beta коэффициент нь багшийн мэдлэг 0.393, багшийн чадвар 0.261, багшийн заах арга зүй 0.354, багшийн зан харилцаа 0.393 байгаа нь оюутны сэтгэл ханамжид статистикийн хувьд ач холбогдол бүхий ($P=0.000$) шууд хамааралтай байгаа нь харагдаж байна. Багшийн мэдлэг, чадвар, заах арга зүй, зан харилцааг тус бүр 1 нэгжээр нэмэгдүүлэхэд багшлах боловсон хүчинд өгөх нийт сэтгэл ханамжийг 0.393 (мэдлэг), 0.261 (чадвар), 0.354 (заах арга зүй), 0.393 (зан харилцаа) нэгжээр тус тус өсгөх хандлага харагдаж байна.

Түүнчлэн оюутнуудын сэтгэл ханамжид сургалтын орчин хэрхэн нөлөөлж буйг Регрессийн шинжилгээгээр тодорхойлоход дараах загвар гарсан.

R Square буюу детерминацийн коэффициент 0.551 гарсан байгаа нь сургуулийн гадаад, дотоод орчин, сургалтын хэрэглэгдэхүүн, тав тухтай байдал, ариун цэвэр, халдвар хамгаалал, суралцах сэтгэл зүйн таатай орчин гэсэн 6 үзүүлэлт нь оюутны сэтгэл ханамжийн өөрчлөлтийн 55.1 хувийг тайлбарлаж байна. F-test 36.03 ($P=0.00$) байгаа нь бидний байгуулсан загвар статистикийн хувьд ач холбогдолтой, сургалтын орчны талаарх оюутнуудын сэтгэл ханамжийг тодорхойлж чадаж байгааг харуулж байгаа юм. Beta коэффициент нь сургуулийн гадаад орчин 0.000 ($P=0.999$), дотоод орчин 0.306 ($P=0.000$), сургалтын хэрэглэгдэхүүн 0.585 ($P=0.000$), тав тухтай байдал 0.221 ($P=0.001$), ариун цэвэр, халдвар хамгаалал 0.186 ($P=0.002$), суралцахад таатай сэтгэл зүйн орчин 0.320 ($P=0.000$) гарсан байна. Эндээс дүгнэж үзэхэд гадаад орчноос ($P=0.999$) бусад үзүүлэлтүүд оюутны сэтгэл ханамжтай статистик ач холбогдол бүхий шууд хамааралтай нь харагдаж байна. Сургуулийн дотоод орчин, сургалтын хэрэглэгдэхүүн, тав тухтай байдал, суралцахад таатай сэтгэл зүйн орчин, ариун цэвэр, халдвар хамгаалалыг тус бүр 1 нэгжээр

нэмэгдүүлэхэд сургалтын орчинд өгөх нийт сэтгэл ханамжийг 0.306 (дотоод орчин), 0.585 (сургалтын хэрэглэгдэхүүн), 0.221 (тав тухтай байдал), 0.186 (ариун цэвэр, халдвар хамгаалал), 0.320 (сэтгэл зүйн таатай орчин) нэгжээр тус тус өсгөх хандлага харагдаж байна.

Оюутнуудын ерөнхий сэтгэл ханамж, сурлагын үзүүлэлтийн хамаарлыг Пирсоны корреляцийн коэффициентээр тодорхойлоход $R=0.080$ гарсан нь оюутнуудын сурлагын үзүүлэлт, сэтгэл ханамжийн үзүүлэлттэй хамааралгүй байгааг харуулж байна.

Дүгнэлт

1. Сувилагчийн мэргэжлээр суралцаж буй оюутнууд сургалтын орчин болон багш нарын мэдлэг (67.9% нь багш нарын хэлний мэдлэгт сэтгэл ханамжгүй), чадвар, заах арга зүй, зан харилцаанд маш их сэтгэл ханамжтай, сэтгэл ханамжтай (70-аас дээш хувь) байгаа хэдий ч ерөнхий сэтгэл ханамжийн дундаж оноо 3.9 ± 0.30 байгаа нь багшийн заах арга зүйгээс (4.1 ± 0.46) бусад багшийн мэдлэг, чадвар, зан харилцаа, сургалтын орчинг улам сайжруулах шаардлагатайг харуулж байна.
2. Оюутны сэтгэл ханамжид багшийн мэдлэг, чадвар, заах арга зүй, зан харилцаа ($P=0.000$), сургалтын дотоод орчин ($P=0.000$), сургалтын хэрэглэгдэхүүн ($P=0.000$), тав тухтай байдал ($P=0.001$), ариун цэвэр, халдвар хамгаалал ($P=0.002$), суралцахад таатай сэтгэл зүйн орчин ($P=0.000$) зэрэг нь статистикийн ач холбогдол бүхий ($P=0.000$) шууд хамааралтай, харин оюутнуудын сурлагын үзүүлэлт, сэтгэл ханамжийн үзүүлэлттэй хамааралгүй ($R=0.080$) байна.

Ном зүй

1. Батзориг.Б, (2011) Биостатистик. УБ
2. Бэгз.Н, (1996) Боловсролын онол, аргазүйн асуудалд. УБ
3. Дамдинсүрэн.А, (2003) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын хөгжил. УБ
4. ДЭМБ.Эрүүл мэндийн судалгааны арга зүй. Манил, 2000
5. Жаргалсайхан.Ш, (2005) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сувилагч, тусгай мэргэжилтний гүйцэтгэх үүрэг, тулгамдсан асуудал.13.,р.5-8
6. Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого. УБ.,2008 Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр. УБ.,2012
7. Монголын менежмент консалтинг. Мэргэжлээ сонгох нь. УБ.,2013
8. Нээлттэй нийгэм форум. Мониторингийн гарын авлага. УБ.,2007
9. Суралцагчдаас авсан судалгааны асуулга